



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/264

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/143 дүгээр тушаал, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.4, 4 аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 9 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Цагаан-Уул сумын Засаг даргын хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Хүнс хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/143 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Цагаан-Уул суманд үлийн цагаан оготнын тархалтыг хумих үйл ажиллагаанд зориулагдах микробиологийн бэлдмэл авах зардалд 7,500,000 (Долоон сая таван зуун мянган) төгрөгийг зарцуулсугай

2. Дээрх зардлын 7,500,000 (Долоон сая таван зуун мянган) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг заавар зөвлөмжийн дагуу хүн, малын аюулгүй байдлыг ханган, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Цагаан-Уул сумын Засаг дарга (С.Гончигням), мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

6717010370